

I-III/2021


Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 14



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого 11.9 хувиар өслөө

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2021 оны эхний улиралд 350.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс оноос 37.2 (11.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого, улирлаар, тэрбум төгрөг



Энэхүү өсөлтөд утасгүй холбооны үйлчилгээнээс олсон орлого 30.2 (16.8%) тэрбум төгрөг, шуудангийн үйл ажиллагаанаас олсон орлого 2.5 (45.9%) тэрбум төгрөг, компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйлчилгээнээс олсон орлого 2.1 (9.0%) тэрбум төгрөг өөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2020 оны 4 улирлаас 3.2 (0.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн 1 дүгээр улирлаар байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2021* I-III
Суурин утасны цэг, мян. Шир	313.5	308.1	316.7
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мян. хүн	4 211.7	4 204.2	4 388.3
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид	865 376	905 362	927 700

Суурин утасны цэгийн тоо 2021 оны 1 дүгээр улиралд 316.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 8.6 (2.8%) мянган цэгээр өссөн байна. Энэхүү өсөлтөд Улаанбаатар хотын суурин утасны цэг 4.5 (1.8%) мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2021 оны 1 дүгээр улиралд 927.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 22.3 (2.5%) мянган хэрэглэгчээр өссөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид өсөхөд Өмнөговь аймагт 4.0 (14.4%) мянга, Дархан-Уул аймагт 3.0 (13.8%) мянга, Хөвсгөл аймагт 2.8 (10.2%) мянган хэрэглэгчдээр өссөн нь нөлөөлөв.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 2021 оны 1 дүгээр улиралд 4.4 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 184.1 (4.4%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 109.8 (5.2%) мянга, Баян-Өлгий аймагт 17.2 (18.0%) мянга, Дархан-Уул аймагт 12.5 (11.0%) мянга, Ховд аймагт 11.9 (12.7%) мянга, Дорнод аймагт 6.5 (6.8%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Интернэт хэрэглэгчдийн тоо 2021 оны 1-р улиралд 3.9 сая болж, үүнээс үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч 3.6 сая, гэрээт интернэт хэрэглэгчид 321.0 мянга байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 2021 оны 1-р улиралд 1.5 сая ширхэгт хүрч, өмнөх оны мөн үеэс 760.9 мянган ширхгээр (34.3%) буурсан байна. Энэхүү бууралтад дотоодын шуудан, илгээмж 755.4 мянга (35.7%), улс хоорондын гарах шуудан, илгээмж 3.4 мянга (13.5%), улс хоорондын орох шуудан илгээмж 2.0 мянган ширхгээр (2.8%) буурсан нь нөлөөлсөн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2021 оны эхний улиралд 187.3 мянган ширхэг бичиг, захидал, 50.9 мянган ширхэг боодол, 131.5 мянган ширхэг илгээлт, 56.2 мянган ширхэг буухиа, 149.4 мянган ширхэг бизнес захидал, 40.0 мянган ширхэг гибрид шуудан, 7.0 мянган ширхэг цахим худалдааны илгээмж, 833.7 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.

Хүснэгт 2. Шуудангийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний улирлаар

Шуудан илгээмжийн урсгал	Бүгд		Дотоод шуудан		Улс хоорондын гарах		Улс хоорондын орох	
	2020 I-III	2021* I-III	2020 I-III	2021* I-III	2020 I-III	2021* I-III	2020 I-III	2021* I-III
	мянган ширхэг							
Нийт шуудан, илгээмж	2 217.0	1 456.1	2 118.9	1 363.4	25.3	21.9	72.8	70.7
Бичиг захидал	264.4	187.3	231.6	178.2	13.9	1.8	18.9	7.4
Боодол	36.3	50.9	16.2	34.4	2.0	2.0	18.1	14.5
Илгээлт	50.4	131.5	26.6	93.5	3.2	8.9	20.6	29.0
Буухиа	33.5	56.2	12.1	27.3	6.2	9.2	15.2	19.8
Бизнес захидал	188.8	149.4	188.8	149.4	-	-	-	-
Гибрид шуудан	45.2	40.0	45.2	40.0	-	-	-	-
Цахим худалдааны илгээмж	3.7	7.0	3.7	7.0	-	-	-	-
Хэвлэл	1 594.6	833.7	1 594.6	833.7	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

- Суурин телефон цэг гэж нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг ойлгоно.
- Сансрын холбооны хэрэглэгчид сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.
- Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно.

- Гибрид шуудан гэж хэрэглэгчээс мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авч, хэвлэн дугтуйлан битүүмжилж хаягт эзэнд нь хүргэх шуудангийн илгээмж юм.
- Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно.
- Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмж юм.

Эх үүсвэр: ҮСХ, мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн мэдээ



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын,
статистикч О.Мандахзориг
Утас: (976-51)-261563*

